



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/183

Улаанбаатар хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10, Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2019 оны 07 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Онцгой байдлын байгууллагын хүний нөөц, сургалт хөгжлийн хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр”-ийг хоёрдугаар, “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-г гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг байгууллагын жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт даалгасугай.

3. Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд гаргаж байхыг Захиргааны удирдлагын газар (хурандаа Л.Болдбаатар), хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр дүн, шинжилгээ хийж, даргын зөвлөлд танилцуулахыг Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газар (хурандаа Г.Бат-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/12 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

00001670

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2019 оны 4-р дугаар сарын 2-ны өдрийн
А/183 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН АЖИЛЛАХ
НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР
/2019-2024 он/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрх зүйн үндэслэл.

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3-т “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ”, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дүгээр зүйлийн 7.1.6-д “агентлаг нь салбарынхаа хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх” гэж тус тус заасан.

1.2. Хэрэгцээ, шаардлага.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын 27.8 хувь нь өөрийн эзэмшлийн орон сууцанд, 36.4 хувь нь байшинд, 16.6 хувь нь гэрт, 19.2 хувь нь түрээсийн байр болон айлд амьдарч байна. Алба хаагчдын 16.6 хувь нь орон сууцны, 3.1 хувь нь автомашины, 62.3 хувь нь цалингийн, 4.6 хувь нь сургалтын болон бусад төрлийн зээлтэй буюу нийт алба хаагчдын 86.6 хувь нь их, бага хэмжээний зээлтэй байна.

Алба хаагчдын 20.3 хувь нь ганцаараа хөдөлмөр эрхэлж /гэр бүлийн гишүүд хөдөлмөр эрхэлдэггүй, өвчтэй, хүүхдээ асардаг гэх мэт шалтгаанаар орлогогүй/ байгаа нь тэднийг амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхөд хамрагдахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нийт алба хаагчдын 7 хувь нь чихрийн шижин өвчинтэй, 38 хувь нь бөөр, шээс ялгаруулах эрхтэн тогтолцооны эмгэгтэй, 20 хувь нь зүрх, судасны эрхтэн тогтолцооны эмгэгтэй, 33 хувь нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгтэй, 9 хувь нь мэдрэлийн эрхтэн тогтолцооны эмгэгтэй байгаа нь ажил мэргэжилтэй холбоотой нь харагдаж байна.

Улсын хэмжээнд стандартад заагдсан гал унтраах зориулалттай автомашины хангалт 36 хувь, алба хаагчийн тусгай зориулалтын хувцас хэрэгслийн хангалт 30 хувь, холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн хангалт 21.7 хувьтай байна.

Дээрх судалгаанаас харахад алба хаагчдын ажиллах, амьдрах ахуй нөхцөлийг сайжруулах, тэдний эрүүл мэндийг хамгаалах, гэр бүлийн гишүүдийн хөгжил, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, алба хаагчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага бий болж байна.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын эрүүл мэндийн байдал, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг дээшлүүлснээр алба хаагчид ажлын байрандаа тогтвор суурьшилтай ажиллах, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үндсэн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, гэр бүлийн хөгжлийг дэмжихэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

- 2.2.1. алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах;
- 2.2.2. алба хаагчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх;
- 2.2.3. алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах;
- 2.2.4. алба хаагчдын гэр бүл, хүүхэд хөгжлийг дэмжих.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ, үр дүн

3.1. “Алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах” зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.1.1. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тусгай зориулалтын хувцас, хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх;

3.1.2. тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх;

3.1.3. ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тавилга, техник хэрэгслээр хангах, стандартын шаардлага хангасан өрөө тасалгааны хүртээмжийг үе шаттай нэмэгдүүлэх;

3.1.4. байгууллагын ногоон байгууламжийг үе шаттай нэмэгдүүлэх, бие даасан дулааны эх үүсвэртэй барилга байгууламжийн тоог бууруулах, эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.5. алба хаагчдын хувцас, хэрэгслийг үйлдвэрлэх, ариутгах, угааж цэвэрлэх туршилт, шинжилгээний төв байгуулах;

3.1.6. алба хаагчдад ажлын байрны болон бэлгийн дарамт учруулах, жендэрийн тэгш бус байдал гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, буруутай этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох;

3.1.7. Гэрээлэгч байгууллагад хүсэлт тавьж гэрээт алба хаагчдын ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах.

Хүрэх үр дүн:

Алба хаагчдын ажиллах нөхцөл сайжирч, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

3.2. “Алба хаагчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх” зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.2.1. алба хаагчдын гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, амь насны даатгалын үнэлгээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.2. амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд олгох мөнгөн урамшууллыг үе шаттай нэмэгдүүлэх;

3.2.3. алслагдсан сум, тосгонд ажиллаж байгаа алба хаагчдын нэмэгдлийг бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх;

3.2.4. ажилтанд өдрийн хоолны болон ажилдаа ирж, буцах унааны зардалд хөнгөлөлт үзүүлэх ба зардлыг эдийн засаг, зах зээлийн байдалтай уялдуулж үе шаттай нэмэгдүүлэх;

3.2.5. алба хаагчдын ажлын гүйцэтгэлийг харгалзан цалингийн шатлал, зэрэглэлийг ахиулах, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэх

3.2.6. Засгийн газрын 2011 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн алба хаагчид орон сууцны дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу алба хаагчдыг орон сууцжуулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.2.7. алба хаагчдыг Засгийн газраас хэрэгжүүлж буй түрээсийн орон сууц, урт хугацааны хөнгөлөлттэй зээлд хамруулах;

3.2.8. байгууллагын орон сууцны фондыг нэмэгдүүлэх, шинээр баригдах гал түймэр унтраах, аврах ангийн барилгыг орон сууцтай байхаар төлөвлөж хэрэгжүүлэх;

3.2.9. орон нутагт томилогдон ажиллаж байгаа удирдах албан тушаалтныг албан тушаалын орон сууцаар хангах, дэмжлэг үзүүлэх;

3.2.10. алба хаагчдыг өмчлөлийн болон эзэмшлийн газартай болох, хувийн хашаа, байшин барихад нь дэмжлэг үзүүлэх асуудлаар орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллах;

3.2.11. алба хаагчдын хэрэгцээнд зориулж хүнсний ногоо тариалах, туслах аж ахуй эрхлэх ажлыг зохион байгуулах;

3.2.12. ердийн галлагаатай гэр, байшинд амьдарч байгаа алба хаагчдад хүйтний улиралд түлшний дэмжлэг үзүүлэх

Хүрэх үр дүн:

Алба хаагчдын нийгмийн асуудал сайжирч, ажлын бүтээмж дээшилнэ.

3.3. “Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах” зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.3.1. эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж алба хаагчдыг жилд нэгээс доошгүй удаа нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээ, сувилгаанд хамруулах;

3.3.2. Давтан сургалт, сэргээн заслын төвд алба хаагч, гэр бүлийн гишүүдийг хөнгөлөлттэй үнээр сувилуулах;

3.3.3. гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.3.4. аюултай, хортой эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг тодорхойлж, үнэлгээ хийлгэх, аюултай, хортой нөхцөлийн нэмэгдлийг олгуулахад шаардагдах зардлыг улсын төсөвт тусгах асуудлыг үе шаттай шийдвэрлэх;

3.3.5. бие бүрэлдэхүүний гамшгийн үеийн сэтгэл зүйн байдлыг судлах, гамшгийн голомтод ажилласан алба хаагчдыг сэтгэл зүй, сэргээн засах эмчилгээнд хамруулах;

3.3.6. алба хаагчдыг жил бүр амралт, сувилалд хөнгөлөлттэй үнээр амрахад нь дэмжлэг үзүүлэх;

3.3.7. төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын эмч нарын өрөөг стандартын дагуу тохижуулж эмнэлгийн тусламж үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.3.8. бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох, ашиглах;

3.3.9. төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад бялдаржуулах, чийрэгжүүлэх, алжаал тайлах танхим байгуулж, тохижуулах, биеийн тамирын бэлтгэлд алба хаагчдыг тогтмол хамруулах;

3.3.10. төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагуудад спортын сургалтын төв, усан сан, амралт, сувиллын газар байгуулах;

3.3.11. алба хаагчдын гэр бүлийн гишүүдэд эрүүл мэндийн болон сэтгэл зүйн тусламж, дэмжлэг үзүүлэх.

Хүрэх үр дүн:

Алба хаагчдын бие бялдрын хөгжил сайжирч, өвчлөл буурах, эрүүл зөв амьдралын хэвшил бүхий гэр бүл бүрдэнэ.

3.3. “Алба хаагчдын гэр бүл хөгжлийг дэмжих” зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.3.1. Өрхийн орлогын нэг гишүүнд ногдох хэмжээ нь амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй алба хаагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.3.2. алба хаагчдыг анх удаа гэр бүл болоход нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, үнэ бүхий эд зүйл дурсгах;

3.3.3. орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт алба хаагчдын гэр бүлийг хамруулан өрхийн үйлдвэрлэл явуулах, туслах аж ахуй эрхлэлтийг дэмжих;

3.3.4. төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагуудад алба хаагчдын хүүхдийн цэцэрлэг үе шаттай байгуулах

3.3.5. алба хаагчдын хүүхдүүдийг хөнгөлөлттэй үнээр зусланд амрахад дэмжлэг үзүүлэх, дотоод нөөц, бололцоог ашиглан амрах нөхцөлийг бүрдүүлэх /Хөвсгөл, Дархан-Уул/;

3.3.6. онцгой байдлын байгууллагын дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулах, алба хаагчдын хүүхдийн хөгжлийг дэмжих, эх оронч хүмүүжил олгох, холбогдох сургалт, арга хэмжээ зохион байгуулах, гэр бүлийн гишүүдэд алба хаагчийн ажил үүргийн онцлог, ачаалал зэргийн талаарх ойлголт, мэдээлэл олгох өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулах,

3.3.7. эмэгтэй алба хаагчдад хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд цолны мөнгийг олгох, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх.

Хүрэх үр дүн

Алба хаагчдын өрхийн орлого нэмэгдэх, алба хаагчдын хүүхдүүд сурч хөгжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж бүрдэж, гэр бүлийн хөгжил төлөвшинэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

4.1. Хөтөлбөрийг 2019-2024 онд хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

4.2.1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнүүд,

4.2.2. улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө,

4.2.3. хандивлагч байгууллага, Олон Улсын байгууллагын дэмжлэг, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт,

4.2.4. гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн болон алба хаагчдын сайн дурын хандив, тусламж,

4.2.5. бусад эх үүсвэр.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах арга хэмжээг Онцгой байдлын

асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн бүтцийн нэгж зохион байгуулна.

5.2. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага энэхүү хөтөлбөр, төлөвлөгөөнд үндэслэн дэд хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

5.3. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн бүтцийн нэгжид ирүүлнэ.


5.4. Захиргааны удирдлагын асуудал хариуцсан бүтцийн нэгж жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайланг нэгтгэнэ.

Зургаа. Хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, болон үр дүнд дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн бүтцийн нэгж жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулна.

___оОо___

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2019 оны 6 дугаар сарын 13 ны өдрийн
А/183... дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН
БАТАЛГААГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
/2019-2024 он/

Д/Д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр	Хүрэх үр дүн	
1	2	3	4	5	
Зорилт 1. Алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах					
1.	1.1. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тусгай зориулалтын хувцас, хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх	2019-2024	Улсын төсөв, хандив, тусламж	Ажлын үр дүн, бүтээмж дээшилнэ, алба хаагчдын аюулгүй байдал хангагдана.	
2.	1.2. Тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	2019-2024			
3.	1.3. Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тавилга, техник хэрэгслээр хангах, стандартын шаардлага хангасан өрөө тасалгааны хүртээмжийг үе шаттай нэмэгдүүлэх	2019-2024		Ажлын үр дүн, бүтээмж дээшилнэ.	
4.	1.4. Байгууллагын ногоон байгууламжийг үе шаттай нэмэгдүүлэх, бие даасан дулааны эх үүсвэртэй барилга байгууламжийн тоог бууруулах, эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	2019-2024		Ажлын байрны нөхцөл, эрүүл ахуйн байдал сайжирна.	
5.	1.5. Алба хаагчдын хувцас, хэрэгслийг үйлдвэрлэх, ариутгах, угааж цэвэрлэх туршилт, шинжилгээний төв байгуулах	2019-2024		Байгууллагын дотоод хүчин чадал бэхжинэ.	
6.	1.6. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын ажлын байрыг эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн болон халуун усны ерөөтэй болгож, тохижуулах	2019-2024		Дотоод нөөц бололцоондоо тулгуурлах	Ажлын байрны нөхцөл, эрүүл ахуйн байдал сайжирна.
7.	1.7. Алба хаагчдад ажлын байрны болон бэлгийн дарамт учруулах, жендэрийн тэгш бус байдал гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, буруутай этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох	2019-2024		Дотоод нөөц, бололцоо, бусад мэргэжлийн байгууллагууд	Ажлын үр дүн, бүтээмж дээшилнэ.
Зорилт 2. Алба хаагчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх					
1.	2.1. Алба хаагчдын гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан	2019-2024	Улсын төсөв	Амь насны болон гэнэтийн	

	өвчин, амь насны даатгалын үнэлгээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, даатгалд хамруулах			ослын даатгалд хамрагдсан байна.
2.	2.2. Амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд олгох мөнгөн урамшууллыг үе шаттай нэмэгдүүлэх	2019-2024	Улсын төсөв	Алба хаагчдын нийгмийн баталгаа сайжирна.
3.	2.3. Алслагдсан сум, тосгонд ажиллаж байгаа алба хаагчдын нэмэгдлийг бий болгох, эрх зүйн орчинг бүрдүүлэх	2019-2024	Улсын төсөв	
4.	2.4. Ажилтанд өдрийн хоолны болон ажилдаа ирж, буцах унааны зардалд хөнгөлөлт үзүүлэх ба зардлыг эдийн засаг, зах зээлийн байдалтай уялдуулж үе шаттай нэмэгдүүлэх	2019-2024	Улсын төсөв	
5.	2.5. Алба хаагчдын ажлын гүйцэтгэлийг харгалзан цалингийн шатлал, зэрэглэлийг ахиулах, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэх	2019-2024	Улсын төсөв	Ажлын үр дүн, бүтээмж дээшилнэ.
6.	2.6. Алба хаагчдыг орон сууцжуулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	2019-2024	Улсын төсөв	Алба хаагчдын амьдрах орчин нөхцөл сайжирна.
7.	2.7. Алба хаагчдыг Засгийн газраас хэрэгжүүлж буй түрээсийн орон сууц, урт хугацааны хөнгөлөлттэй зээлд хамруулах	2019-2024	Алба хаагчдын түрээсийн төлбөр	
8.	2.8. Байгууллагын орон сууцны фондыг нэмэгдүүлэх, шинээр баригдах гал түймэр, унтраах аврах ангийн барилгыг орон сууцтай байхаар төлөвлөж хэрэгжүүлэх	2019-2024	Улсын төсөв	
9.	2.9. Орон нутагт томилогдон ажиллаж байгаа удирдах албан тушаалтныг албан тушаалын орон сууцаар хангах, дэмжлэг үзүүлэх	2019-2024	Тухайн шатны Засаг дарга	Алба хаагчийн тогтвортой ажиллах нөхцөл бүрдэнэ.
10.	2.10. Алба хаагчдыг өмчлөлийн болон эзэмшлийн газартай болох, хувийн хашаа, байшин барихад нь дэмжлэг үзүүлэх асуудлаар орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллах	2019-2024	Тухайн шатны Засаг дарга, Дотоод нөөц, бололцоондоо тулгуурлах	Алба хаагчид эрүүл, таатай орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.
11.	2.11. Алба хаагчдын хэрэгцээнд зориулж хүнсний ногоо тариалах, туслах аж ахуй эрхлэх ажлыг зохион байгуулах	2019-2024	Дотоод нөөц, бололцоондоо тулгуурлах	Хүнсний ногоо тариалах, туслах аж ахуй эрхлэх Онцгой байдлын анги, байгууллага нэмэгдэж, алба хаагчдын хэрэгцээг хангахад нөлөөлнө.
12.	2.12. Ердийн галлагаатай гэр, байшинд амьдарч байгаа алба хаагчдад хүйтний улиралд түлшний дэмжлэг үзүүлэх	2019-2024	Улсын төсөв, Дотоод нөөц, бололцоондоо	Алба хаагчдын амьдралд дэмжлэг болно.

		тулгуурлах	
Зорилт 3. Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах			
1.	3.1. Эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж алба хаагчдыг жилд нэгээс доошгүй удаа нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээ, сувилгаанд хамруулах	2019-2024	Улсын төсөв Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэлт хийх нөхцөл бүрдэнэ, эмчилгээ үйлчилгээнд хамрагдах нөхцөл бүрдэнэ.
2.	3.2. Давтан сургалт, сэргээн заслын төвд алба хаагч, гэр бүлийн гишүүдийг хөнгөлөлттэй үнээр сувилуулах	2019-2024	Улсын төсөв, дотоод нөөц, бололцоо, хувийн зардал Алба хаагч, гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн байдал сайжирна
3.	3.3. Гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	2019-2024	Улсын төсөв, ЭМЯ, ОБЕГ Алба хаагчдын эрүүл мэндийн байдал сайжирч, ажиллаж амьдрах нөхцөл бүрдэнэ
4.	3.4. Аюултай, хортой эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг тодорхойлж, үнэлгээ хийлгэх, аюултай, хортой нөхцөлийн нэмэгдлийг олгуулахад шаардагдах зардлыг улсын төсөвт тусгуулах асуудлыг үе шаттай шийдвэрлэх	2019-2024	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, ОБЕГ, ТОНОББ Алба хаагчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийгдэж мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалтад Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар орсон байна.
5.	3.5. Гамшгийн голомтод ажилласан алба хаагчдыг сэтгэл зүй, сэргээн засах эмчилгээнд хамруулах	2019-2024	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, ОБЕГ Гамшгийн голомтод ажиллах алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүй бэлтгэгдэнэ. Ажиллах нөхцөл бүрдэнэ.
6.	3.6. Алба хаагчдыг жил бүр амралт, сувилалд хөнгөлөлттэй үнээр амрахад нь дэмжлэг үзүүлэх	2019-2024	Дотоод нөөц, бололцоо, хувийн зардал Алба хаагчдын эрүүл мэндийн байдал сайжирна
7.	3.7. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын эмч нарын ерөөг стандартын дагуу тохижуулж эмнэлгийн тусламж үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх	2019-2024	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, ОБЕГ, ТОНОББ Алба хаагчдын эрүүл мэндийн байдал сайжирч, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.
8.	3.8. Бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох, ашиглах	2019-2024	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, ОБЕГ, ТОНОББ Алба хаагчдын мэдээллийн нэгдсэн сантай болно.
9.	3.9. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад	2019-2024	Дотоод нөөц Алба хаагчдын бие бялдрын

	бялдаржуулах, чийрэгжүүлэх, алжаал тайлах танхим байгуулж, тохижуулах, биеийн тамирын бэлтгэлд алба хаагчдыг тогтмол хамруулах		бололцоондоо тулгуурлах	стандарт хангагдана.
10.	3.10. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага спортын сургалтын төв, усан сан, амралт, сувиллын газар байгуулах	2019-2024	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, дотоод нөөц, бололцоондоо тулгуурлах	Алба хаагчдын бие бялдар, эрүүл мэндийн байдал сайжирна
Зорилт 4. Алба хаагчдын гэр бүл хөгжлийг дэмжих				
1.	4.1. Өрхийн орлогын нэг гишүүнд ногдох хэмжээ нь амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй алба хаагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх	2019-2024	Дотоод нөөц, бололцоондоо тулгуурлах	Алба хаагчдын өрхийн орлогод дэмжлэг болно.
2.	4.2. Алба хаагчдыг анх удаа гэр бүл болоход нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, үнэ бүхий эд зүйл дурсгах	2019-2024	Дотоод нөөц, бололцоондоо тулгуурлах	Алба хаагчдын өрхийн орлогод дэмжлэг болно.
3.	4.3. Орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт алба хаагчдын гэр бүлийг хамруулан өрхийн үйлдвэрлэл явуулах, туслах аж ахуй эрхлэлтийг дэмжих	2019-2024	Дотоод нөөц, бололцоондоо тулгуурлах	
4.	4.4. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад алба хаагчдын хүүхдийн цэцэрлэг үе шаттай байгуулах	2019-2024	Дотоод нөөц, бололцоондоо, Төсөл, хөтөлбөр	Ажиллах нөхцөл боломж бүрдэнэ.
5.	4.5. Алба хаагчдын хүүхдүүдийг хөнгөлөлттэй үнээр зусланд амрахад дэмжлэг үзүүлэх, дотоод нөөц, бололцоог ашиглан амрах нөхцөлийг бүрдүүлэх /Хөвсгөл, Дархан-Уул/;	2019-2024	Дотоод нөөц, бололцоондоо тулгуурлах	Алба хаагчдын хүүхдүүд чөлөө цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж бүрдэнэ.
6.	4.6. Онцгой байдлын байгууллагын дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулах, алба хаагчдын хүүхдийн хөгжлийг дэмжих, эх оронч хүмүүжил олгох, холбогдох сургалт, арга хэмжээ зохион байгуулах, гэр бүлийн гишүүдэд алба хаагчийн ажил үүргийн онцлог, ачаалал зэргийн талаарх ойлголт, мэдээлэл олгох өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулах	2019-2024	Дотоод нөөц, бололцоондоо тулгуурлах	Алба хаагчдын хүүхдийг хамгаалах, тэдний аюулгүй байдал хангагдана.
7.	4.7. Эмэгтэй алба хаагчдад хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд цолны мөнгийг олгох, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх	2019-2024	Улсын төсөв	Алба хаагчдын өрхийн орлогод дэмжлэг болно.

___оОо___